

УВС АЙМГИЙН 2017 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ЭРҮҮ, ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2017.05.04

Улаангом сум

Нэг. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХИ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Увс аймгийн цагдаагийн газарт 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2017 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 221, зөрчлийн шинжтэй 590, бусад-137 шийдээгүй үлдсэн-42 нийт-990 гомдол, мэдээлэл хүлээн авсан. Өмнөх оны мөн үеэс -25 нэгжээр буюу -2.5 хувиар буурсан байна.

Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн гэмт хэргийн шинжтэй 221 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад -41 нэгжээр буюу -15,6 хувиар буурсан байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийн 118 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, 103 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай Прокурорын хяналтанд хүргүүлж шийдвэрлэсэн. Захиргааны зөрчлийн шинжтэй 590 гомдол мэдээлэл хүлээн авснаас 416 буюу 70,5 хувийг шийтгэврийн хуудсаар, 48 буюу 8,1 хувийг торгуулийн хуудсаар торгож, 46 буюу 7,7 хувийг баривчлах, 77 буюу 13,0 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч торгох шийтгэл ноогдуулан шийдвэрлэсэн.

Архидан согтуурч захиргааны зөрчил гаргасан 221 хүнийг саатуулсан нь +7 нэгжээр өссөн байна.

ЗХАБТХ, ГБХТТХ-иар Увс аймгийн сум дундын шүүхээр 46 иргэнийг 7-14 хоногоор баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс 28 нэгжээр буюу +155.6 хувиар өссөн.

Торгуулийн хуудсаар, бэлэн бус торгуулиар 2674 зөрчилд 61.862.000 төгрөгний торгууль, шийтгэврийн хуудсаар 557 зөрчилд 55.733.000 төгрөгний торгууль ногдуулсан.

Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг: Аймгийн хэмжээнд 110 гэмт хэрэг бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс +18 хэргээр буюу +19.6 хувиар өссөн байна.

- Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 91.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс +17.2 хувиар өссөн.

Хэргийг ангиллаар нь авч үзвэл: хөнгөн гэмт хэрэг-77, хүндэвтэр гэмт хэрэг-31, хүнд-2, онц хүнд гэмт хэрэг бүртгэгдээгүй.



2017 оны эхний 04 сарын байдлаар 77 буюу 70.0 хувьд нь хэрэг бүртгэлт, 33 буюу 30.0 хувьд нь мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. Хялбаршуулсан журмаар 58 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33 хэргээр буюу 132.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

-61 хэрэг буюу 55.4 хувь нь бусад суманд

-49 хэрэг буюу 44.5 хувь нь Улаангом сумдын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн

Гарсан гаригаар нь авч үзвэл:

-Даваа-17

-Мягмар-18

-Лхагва-15

-Пүрэв-17

-Баасан-17

-Бямба-13

-Ням-13

Гэмт хэргийг гарсан цагаар нь авч үзвэл:

-06-14 цагт -17

-14-19 цагт-26

-19-22 цагт-30

-22-06 цагт-37 тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас :

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад учирсан 138.500.000 төгрөгний хохиролын 131.000.000 төгрөгний хохиролыг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь нь 94.5 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад +5.5 хувиар өссөн. Иргэд аж ахуй нэгж байгууллагаас 201.300.000 төгрөгний хохирол битүүмжилж ажилласан.

Үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:

-Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг -2

-Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг-50

-Танхайрах гэмт хэрэг-2

-Хүчиндэх-1

-Иргэдийн өмчийн хулгай-11

-Малын хулгай -21

-Тээврийн хэрэгслийн хулгай-1

-Залилан мэхлэх-1

-Завших, үрэгдүүлэх-1

-ТХХАБЖЭГХ / 215 / -2

-БХЖЭГХ-1

-Гээгдэл эд зүйл, мал ашиглах-10 тус тус бүртгэгдсэн байна.

Үйлдэгдсэн бүх хэргийн 33 буюу 30.0 хувь нь хулгайн хэрэг, хулгайн хэргийн 21 буюу 63.6 хувийг мал хулгайлах хэрэг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад +13 хэргээр буюу +162.5 хувиар өссөн. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 11 байгаа нь өмнөх оноос -1 хэргээр буюу 8.3 хувь буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргүүдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл, хүүхэд оролцсон гэмт хэрэг +3 нэгжээр, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг +10 нэгжээр, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг +1 нэгжээр, гэр орон сууц +5 нэгжээр, *гэр бүлийн хүчирхийллийн* улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг +4 нэгжээр тус тус өсч бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг-1, эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн гэмт хэрэг -4 нэгжээр тус тус буурсан байна.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН: МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

М.ОДХҮҮ